



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/859

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасгийн засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Вилла проект” ХХК-тай 138 909 828 (нэг зуун гучин найман сая есөн зуун есөн мянга найман зуун хорин найм) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Вилла проект” ХХК-ийн захирал (Ч.Сод-Эрдэнэ)-д даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323911038

Аймгийн Засаг даргын 2023 оны
12 дугаар сарын 28-ны өдрийн
1/89 дугаар захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	2,290,499	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	2,290,499	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	1,145,249	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	7,000,000	Ү.Бямбасүрэн
5	Нормчлолын сан	206,145	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
7	Ажил гүйцэтгэх хугацаа	40 хоног	Ү.Бямбасүрэн